

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тендерийн нэр: Усны хувцас, гутал
Тендерийн код: МРЦМ/ 20240102249

Нийлүүлэх барааны нэр төрөл, тоо хэмжээний мэдээлэл

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нийлүүлэгдэх газар
1	Резинэн усны хувцас /хос/	хос	187	“Бор-Өндөр” УБҮ
2	Усны гутал	хос	402	“Бор-Өндөр” УБҮ
3	Усны гутал/ Өвлийн дотортой /	хос	180	“Бор-Өндөр” УБҮ

Загвар бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

- Холбогдох стандартын шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх, хянан тодорхойлох зорилгоор чанар, тохирлын гэрчилгээнээс гадна загвар бүтээгдэхүүнийг биетээр хүлээн авч, туршилт хийнэ. Энэ зорилгоор нэг төрлийн бүтээгдэхүүнээс 1 хосоос багагүй загварыг үнэлгээний зориулалтаар ирүүлнэ. Загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй болно.
- Шалгарсан оролцогчийн загвар бүтээгдэхүүнийг барааг / усны гутал, усны хувцас / бүрэн гүйцэд нийлүүлж дуусах хүртэл харьцуулан шалгаж, хүлээн авах зорилгоор буцаан олголгүйгээр ашиглана.
- Бараа нь шинэ байх бөгөөд тус бүрээр нь гялгар уутанд савласан байх бөгөөд гялгар углаа боодол нь тоос шорооноос хамгаалсан, ус чийг нэвтрэхгүй, барааны хадгалалтын явцад хуучирч муудахгүй байх нөхцөлийг хангахаар савласан байна.

Баглаа, боодол: Ус чийг, тоос шороо нэвтрэх, хэлбэр алдахаас хамгаалсан зориулалтын савлагаатай байх, бараа тус бүрийн савлагааны гадна талд гуталны хэмжээг харагдахуйцаар тэмдэглэсэн байна. Усны хувцас болон усны гутал дээрх хаяглалт нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Өмсгөл хэмжээ
- Барааны тэмдэг
- Загварын дугаар
- Үйлдвэрлэсэн огноо
- Стандартын дугаар
- Үйлдвэрлэсэн улс

Барааны тэмдэгийг гуталны хувьд улны гадна болон түрийн хэсэгт тэмдэглэсэн байна.

1. РЕЗИНЭН УСНЫ ХУВЦАС /ХОС/

1.1. Барааны тодорхойлолт:

- 1.1.1. “Бор-Өндөр” УБҮ-ийн Уулын цехийн далд уурхайн ажилчид, Ил уурхайн ажилчид болон бусад цехийн ажилчид бүх улиралд өмсөхөд ус чийгнээс хамгаалах зорилгоор ашиглах ажлын усны хувцас байна.
- 1.1.2. Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага.MNS 13688:2000” Монгол улсын стандарттай дүйцэхүйц стандартын шаардлагыг хангасан байна.
- 1.1.3. Резинэн усны хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх.

1.1.4. Удаан эдэлгээтэй, салхи, ус, тос масло нэвтэрдэггүй.

1.2. Усны хувцасны загвар материал

- 1.2.1. Товчлоосоор ус орохос сэргийлэх даралт /планктай/ байх.
- 1.2.2. Усны хувцасны өнгө-шар, юудэн малгайтай байна.
- 1.2.3. Ханцууйн үзүүрийн хэсгээрээ ус орохос хамгаалах зангуу, товчоор чангартаг байна.
- 1.2.4. Бүсэлхийн хэсэгт салхи орохос хамгаалж дотор талдаа гүйдэг уяатай бүстэй байна.
- 1.2.5. Өмд нь бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөх резинэн оруулгатай.
- 1.2.6. Өмдний мөр нь уртасгаж, богиносгох зориулалттай резинэн мөртэй, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой байна.
- 1.2.7. Шуумагийг зангуу, эсвэл товчоор нарийсгах боломжтой байх.
- 1.2.8. Усны хувцасны материал: полиэфир, ПВХ хучлагатай, нуруу цээж хэсэгт гэрэл ойлгогч оруулгатай байж болно.
- 1.2.9. Усны хувцасны оёдол урагдахаас хамгаалсан давхар бэхэлгээтэй байна.

Усны хувцас, хослол Жишиг зураг



Резинэн усны хувцасны шаардлагатай өмсгөл болон тоо хэмжээний мэдээлэл (нэгж: хос)

АЗИ размер	Цээжний тойрог /см/	Бүсэлхийн тойрог /см/	Ташааны тойрог /см/
3XL	99	81	107
4XL	104	86	112
5XL	109	91	117
6XL	115	102	123

Размерийн хүснэгт (нэгж: хос)

Хэрэглэгч	Өмсгөл размер, /АЗИ размер/				Нийт
	3XL	4XL	5XL	6XL	
“Бор-Өндөр” УБҮ	30	50	50	57	187

2. УСНЫ ГУТАЛ

2.1. Барааны тодорхойлолт:

- 2.1.1. Усны гутал нь EN ISO 20345:2011 стандарт эсхүл “Хөлний хамгаалалт, ажлын тусгай гутал” MNS 5623:2006 стандартын шаардлагыг хангасан байна.
- 2.1.2. Ажлын усны гутал нь ажилтныг уул уурхайн үйлдвэрлэл, түүний дотор далд уурхай, ашигт малтмалын баяжуулах фабрик болон бусад хэсгүүдэд ажиллахад ашиглах зориулалттай.
- 2.1.3. Уурхайн ус, баяжуулалтын ус, чийг, шингэн, булинга, химиин бодис зэрэг шингэний бохирдоос хамгаалах.
- 2.1.4. Цахилгаан болон механик нөлөөлөл (үүний дотор –цохилт, цоо хатгалт, эсгэлт, нугаралт, үрэлт зэрэг) үйлдвэрлэл болон онцгой нөхцөлд тохиолдож болзошгүй гэмтэх

эрсдэл, ажлын байрны орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах зориулалттай хүний эрүүл мэндэд тохирсон зориулалтын хэрэгсэл байна.

- 2.1.5. Ус чийг, булинга, химиин бодистой орчинд ажиллахад тэсвэртэй, цахилгаан дамжуулдаггүй.
- 2.1.6. Усны гутал нь хүчилд тэсвэртэй, тосонд тэсвэртэй, хүйтэнд хагарч хугардаггүй, цоординдоггүй, халтирдаггүй, элэгдэлд тэсвэртэй, дулааныг хамгаалдаг байна.

2.2. Барааны материал:

- 2.2.1. Усны гутал нь (DUNLOP) брэндийн усны гутал эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.
- 2.2.2. Гуталны гадар нь резин, ул нь полимер эдлэлээр хийгдсэн байх ба дотор хэсэг нь даавуун доторлогоотой, бат бөх хийцтэй байна.
- 2.2.3. Усны гутал нь устай, шавартай нөхцөлд ажиллах зориулалттай тул ул нь халтирахаас хамгаалсан зууралт сайтай резин, полимер ултай байна.

2.3. Барааны загвар, хамгаалалт:

- 2.3.1. Хуруу, шагайн хамгаалалт 200 джоул хүртэлх хэмжээний цохилтыг даахуйц байна.
- 2.3.2. Улавч нь 1200Н хүртэлх шууд цоо хатгах хүчийг даахуйц материалыаар хийгдсэн байна.
- 2.3.3. Гутлын урд хоншоорт нэмэгдэл резинэн зөөлөвчтэй байх, шагай тавхайн хэсэгт хүчитгэсэн хамгаалалттай байх.
- 2.3.4. Ул болон өсгий нь элэгдэлд тэсвэртэй, халтирдаггүй материалыаар хийгдсэн байна.
- 2.3.5. Гутлын өндрийн хэмжээ 37 см –ээс багагүй байх.

Усны гутал: Жишиг зураг:



Усны гуталны шаардлагатай өмсгөл болон тоо хэмжээний мэдээлэл (нэгж: хос)

Хэрэглэгч	Өмсгөл размер,									Нийт
	37	38	39	40	41	42	43	44	45	
“Бор-Өндөр” УБҮ	5	40	50	80	80	80	50	15	2	402 хос

3. УСНЫ ГУТАЛ /ӨВЛИЙН ДУЛААЛГА ДОТОРТОЙ /

3.1. Барааны тодорхойлолт:

- 3.1.1. Өвлийн усны гутал нь нь EN ISO 20345:2011 стандарт, эсхүл “Хөлний хамгаалалт, ажлын тусгай гутал” MNS 5623:2006, стандартын шаардлагыг хангасан байна.
- 3.1.2. Өвлийн усны гутал нь -30 градус хүртэл орчинд устай, чулуулаг, шавартай нөхцөлд ажиллах зориулалттай тул ул мөс цасанд халтирахаас хамгаалсан зууралт сайтай ултай байна.
- 3.1.3. Өвлийн дотортой усны гутал нь (DUNLOP) брэндийн усны гутал эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.
- 3.1.4. Өвлийн дотортой гутал нь хүчилд тэсвэртэй, тосонд тэсвэртэй, хүйтэнд хагарч хугардаггүй, цоординдоггүй, халтирдаггүй, элэгдэлд тэсвэртэй, дулааныг хадгалах чадвартай байна.

3.2. Өвлийн усны гуталны загвар, хамгаалалт:

- 3.2.1. Хуруу болон шагайн хамгаалалт 200 джоул хүртэлх хэмжээний цохилтыг даахуйц

- 3.2.2. Улавч нь 1200Н хүртэлх шууд цоо хатгах хүчийг даахуйц
- 3.2.3. Гутлын урд хоншоорт нэмэгдэл резинэн зөөлөвчтэй байх, шагай тавхайн хэсэгт хүчитгэсэн хамгаалалтай байх.
- 3.2.4. Ул болон өстий нь элэгдэлд тэсвэртэй, халтиргагүй материалыар хийгдсэн байна.
- 3.2.5. Гутлын өндрийн хэмжээ 37 см –ээс багагүй байх.

3.3. Материал:

- 3.3.1. Дотор материал нь. Үрэлтэд тэсвэртэй ноосон үслэг дотортой -30 градус хүртэл орчинд дотор дулаанаа алдахгүй давхар хамгаалалтай байна.
- 3.3.2. Гадна тал нь өвлийн хүйтэн, сэргүүн нөхцөлд ажиллахад гадна талын материал хугарахгүй, хагарч цуурдаггүй байх ба гутлыг тайлахад зориулсан өсгийн нэмэлт оруулгатай байна.
- 3.3.3. Усны гутлын материал нь элэгдэлд тэсвэртэй тусгай зориулалтын резинэн болон полимер материалыаар хийгдсэн байх бөгөөд улавчны материал болон хээ нь халтирахгүй нөхцлийг хангах, ашиглалтын үед ялангуяа нам температурт хөлдөх үед уян хатан чадвараа хадгалах чадвартай, халтирахгүй нөхцлийг хангасан байна.

Өвлийн дотортой усны гутал: Жишиг зураг:



Усны гуталны шаардлагатай өмсгөл болон тоо хэмжээний мэдээлэл (нэгж: хос)

Хэрэглэгч	Өмсгөл размер,						Нийт
	39	40	41	42	43	44	
“Бор-Өндөр” УБҮ	10	20	50	50	40	10	180 хос

Зураг төсөл: Шаардахгүй

Барааг шалгаж хүлээн авах:

1. Барааг “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн Төв агуулахад хүлээн авахад нийлүүлэгчийн төлөөлөгч байлцана.
2. Нийлүүлэх барааг “Бор-Өндөр” УБҮ-ийн холбогдох цехийн удирдлагууд ирж хүлээн авч, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаж байгаа эсэх тухай дүгнэлт гаргана. Дүгнэлтээр туршиж үзэх шаардлагатай гэж үзвэл эд материалыас дээж авч туршина.
3. Техникийн тодорхойлолт болон чанарын шаардлага хангаагүй гэж үзсэн барааг захиалагч хүлээн авахгүй